



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/53

Улаанбаатар хот

Байгууллагын архивын баримтад
тооллого хийх комисс томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.5 дахь заалт, Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 7.1, 7.3, 7.5.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын архивын хадгаламжийн нэгжийн бодит тоог тогтоох, тоо бүртгэлийн баримт бичигт тусгагдсан тоотой тохирч буй эсэхийг шалгах, механик болон биологийн гэмтлээс урьдчилан сэргийлэх, сэлбэн засах шаардлагатай баримтыг илрүүлэх зорилгоор архивын баримтад тооллого явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Н.Ганболд

Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

Д. Цэрэнлхам

Захиргаа, удирдлагын хэлтсийн Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын мэргэжилтэн

Б.Янжинлхам

Хууль эрх зүйн хэлтсийн хуулийн мэргэжилтэн

В. Хишигдэлгэр

Бичиг хэргийн ажилтан

Л. Одмаа

Архивын ажилтан

2. Үзлэг тооллогыг 2025 оны 10 дугаар сарын 20-ний өдрөөс 11 дүгээр сарын 03-ны өдрийн дотор зохион байгуулсугай.

3. Тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, бодитой, зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, акт үйлдэн 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга /Н.Ганболд/-д даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132003293